



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/37

Маңдалговь

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, байгууллагын хамт олны 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Байгууллагын албан хаагчдын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг 5 гишүүнтэй байхаар тогтоож, дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар томилсугай.

Зөвлөлийн дарга: -Г.Самданцоодол (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)

Гишүүд : -Н.Сүхбаатар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
-С.Цэнгэлмаа (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
-Р.Лхагвадорж (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
-Г.Жавзмаа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж ажиллахыг Ёс зүйн зөвлөл (Г.Самданцоодол)- д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

486190162